

**“МОНГОЛ ОРНЫ ОЙН НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ,
ЦААШДЫН ЧИГ ХАНДЛАГА” сэдэвт үндэсний 5 дугаар хурал**
2021 оны 03-р сарын 19, Улаанбаатар хот, Монгол улс

ОЙН ҮРИЙН ГЕНЕТИК НӨӨЦИЙН ХАМГААЛЛЫН АСУУДАЛД

Б.Удвал, Н.Батхүү






ШУА-ийн Газарзүй, геоэкологийн хүрээлэн, МУИС, ХШУИС



ОРШИЛ

Дэлхийн ургамлын генетикийн төрөл зүйлийг хадгалах, тогтвортой ашиглах шаардлага урьд өмнө байгаагүйгээр тулгамдаж байна. Сүүлийн жилүүдэд дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөгдөл, байгаль орчны доройтол нь ойн үрийн генетик нөөцөд сөрөг нөлөө үзүүлсээр байна. Иймээс ойн үрийн генетик нөөцийг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох шаардлага тулгарч байна.

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050, дунд хугацааны бодлогын баримт бичиг “МУ-ыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, “Төрөөс ойн талаар баримтлах бодлого”, богино хугацааны хөгжлийн төлөвлөлтийн баримт бичиг Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны төлөвлөгөөнд туссан ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээг 8.6 хувьд хүргэх зорилт тавьсан байна. Энэхүү бодлогын баримт бичиг, хөтөлбөрийн зорилтыг хангахын тулд Монгол орны нөхцөлд дасан зохицсон, амьдрах чадвартай сайн чанарын модны үрээр тарьц суулгац ургуулах, шилмэл, сайн чанарын модны үр түүх байнгын талбайнуудыг байгуулах, жилд бэлтгэх үрийн хэмжээг нэмэгдүүлэх, зонхилох модны үрийн сантай болох, аймаг, нийслэл, сумын түвшинд модны тарьц суулгац ургуулахад шаардагдах үрийн нөөцтэй болох тал дээр анхааран ажиллах нь зүйтэй байна.



Үрийн талбайн үнэлгээ (2011-2015)

2011-2015 онд улсын төсвийн болон орон нутгийн хөрөнгөөр сонгон тусгаарласан ойн үрийн талбайг бүртгэлжүүлэх ажлын хүрээнд БОАЖЯ-наас гаргасан “Улсын болон орон нутгийн хөрөнгөөр сонгон тусгаарласан ойн үрийн байнгын талбай”-н жагсаалтын дагуу төслийн багийн боловсруулсан шалгуур үзүүлэлт, Ойн үрийн байнгын талбайг байгуулахад тавих ерөнхий шаардлага MNS 6531:2015 стандартын дагуу үнэлж бүртгэлжүүлэх ажлыг гүйцэтгэсэн бөгөөд 3 аймгийн хэмжээнд 26 үрийн талбайд үнэлгээ өгөхөд 70 гаруй хувь нь шаардлага хангахгүй байсан байна.



Нарсан ойн үрийн талбайн үндсэн үзүүлэлт

№	Үзүүлэлт		(CODE: Khen1)	(CODE: Khen2)	(CODE: Khen3)	(CODE: Khen6)
1	Модны латин нэр		<i>Pinus sylvestris</i>	<i>Pinus sylvestris</i>	<i>Pinus sylvestris</i>	<i>Pinus sylvestris</i>
2	Модны монгол нэр		Эгэл нарс	Эгэл нарс	Эгэл нарс	Эгэл нарс
3	Категори	Сонгогдсон	√	√	√	√
		Чанарын				
		Шалгагдсан				
4	Материалын эх үүсвэрийн төрөл/	Таримал				
		Байгалийн	√	√	√	√
5	Газарзүйн байршил	Уртраг	110°28'42.9"	110°25'29.8"	109°21'02.5"	111°11'31.6"
		Өргөрөг	48°38' 33.7"	48°38'30.6"	48°02'34.3"	49°11'43.1"
		Дтд	1103 м	1198 м	1424 м	1066 м
6	Гарал үүсэл	Орон нутгийн	√	√	√	√
		Орон нутгийн бус				
		Мэдэхгүй				
7	Генетикийн өөрчлөлтөнд орсон эсэх		үгүй	үгүй	үгүй	үгүй
8	Үрийн талбайг баталгаажуулсан он		2012	2013	2013	2014
9	Талбайн төрөл	Байнгын	√	√	√	√
		Түр				
		Сор, шилмэл мод бүхий				
10	Эзэмшигч		Хэний аймгийн БОАЖГ	Хэний аймгийн БОАЖГ	Хэний аймгийн БОАЖГ	Хэний аймгийн БОАЖГ
11	Үрийн талбайг тусгаарласан байгууллага		“Биндэр” СДОА	“Биндэр” СДОА	“Биндэр” СДОА	“Хэнтийн шинэс” СДОА
12	Үрийн район					
13	Аймаг		Хэнтий	Хэнтий	Хэнтий	Хэнтий
14	Сум, газрын нэр		Дадал, Өвгөдийн өвөр	Янгийн ар	Биндэр, Өвөр хүүрт	Өмнөдэлгэр, Их өлзийт
15	Үрийн талбайг баталгаажуулсан байгууллага		Аймгийн БОАЖГ	Аймгийн БОАЖГ	Аймгийн БОАЖГ	Аймгийн БОАЖГ
16	Ойн сангийн газрын төрөл (байгалийн, таримал, тармаг)		Таримал	Байгалийн	Таримал	Байгалийн
17	Ойн бүсийн төрөл (ТХГ, Ногоон бүс, голын хамгаалалт, ашиглалтын бүс, төгөл ой, баян бүрд г.м)		Онцгой бүс	Ногоон бүс	Ногоон бүс	Ногоон бүс

18	Ландшафт	Бэл	Дунд налуу	Дунд налуу	Дунд налуу
19	Талбайн хэмжээ	5 га	5 га	10 га	5 га
20	Ойн хэв шинж	Улалж алаг өвст тайгархаг нарсан ой	Алаг өвст тайгархаг нарсан ой	Сийрэг алаг өвст тайгархаг нарсан ой	Үетэн алаг өвст тайгархаг нарсан ой
21	Хөрсний хэв шинж	Сул чандруулаг элсэн хөрс	Сул чандруулаг элсэн хөрс	Сул чандруулаг элсэн хөрс	Ойн бараан хөрс
22	Ойн бүрэлдэхүүн	10 Н	10 Н	10 Н	10Ш
23	Газрын налуу градус, чиглэл	3°	5°	Х3°	ЗХ 11°
24	Ойн чансаа	III	III	III	II
25	Селекцийн үнэлгээ	Хэвийн	Хэвийн	Хэвийн	Доогуур чанарын
26	Нас/насны анги	II	IV	II	III
27	Өтгөрөл	0.6	0.9	0.6	0.4
28	Дундаж өндөр, см	8.3	19.5	9.6	14.8
29	Дундаж диаметр, м	12.2	26.1	13.3	26.2
30	Титмийн хэлбэр (зөв, зөв бус)	Зөв	Зөв	Зөв бус	Зөв бус
31	Ишний хэлбэр (конус, шулуун, цилиндр, салаалсан, мушгирсан)	Шулуун	Шулуун	Шулуун	Конус
32	Мөчирлөсөн байдал (нарийн, бүдүүн, жигд бус)	Нарийн	Нарийн	Нарийн	Жигд бус
33	Хамгийн доод амьд мөчир хүртлэх өндөр, м	1.8	3.5	1.8	1.4
34	1 га талбай дахь модны тоо, ш	1280	600	1240	240
35	Эрүүл мэндийн ангилал	2	1	3	2
36	Гэмтлийн ангилал	2	0	6	6
37	Санхүүжилтийн эх үүсвэр	Улсын төсвийн хөрөнгө	Улсын төсвийн хөрөнгө	Улсын төсвийн хөрөнгө	Улсын төсвийн хөрөнгө
38	Тайлбар	Үрийн талбайн шалгуур үзүүлэлтийг хангаагүй	Үрийн талбайн шалгуур үзүүлэлтийг	Үрийн талбайн шалгуур үзүүлэлтийг	Үрийн талбайн шалгуур үзүүлэлтийг хангаагүй



Ургах орчны доройтлоос шалтгаалан моддын титэм сийрэгжсэн, муруй болон салаа мод ихтэй, түймрээс хамгаалах зурвас хийгээгүй, арчилгааны огтлолт хийх муруй, салаалсан, селекцийн ангиллаар доогуур чанарын моддыг тэмдэглэсэн боловч огтлолт хийгээгүй байв. Эдгээр сонгон тусгаарласан эдгээр ойн үрийн байнгын талбайнууд нь “Ойн үрийн байнгын талбайг байгуулахад тавих ерөнхий шаардлага” MNS6531:2015 стандарт болон үрийн талбайг сонгоход тавих шалгуур үзүүлэлтийг хангахгүй байна.



Ойн үрийн байнгын болон түр талбайн үрийн чанарын үзүүлэлтүүд

No	Үрийн талбайн код	Газрын нэр	Байгуулсан он	Зонхилох төрлийн мод	(N)	(E)	ДТД (m)	Үнэлгээний дүн	Үрийн чанарын зэрэг
Хөвсгөл аймаг									
1	Ulaan Uul (Khov 1)	Ulaan Uul, Khudag	2014	<i>Larix sibirica</i> Ldb.	50.4	99.1	1651	Fulfill the criteria	No seed crops available for 2017 and 2018 for Siberian larch in Mongolia
2	Khatgal (Khov 2)	Uvur Ereen	2011	<i>Larix sibirica</i> Ldb.	50.2	100.0	1804	not fulfill the criteria	
3	Chandmani-Undur (Khov 3)	Jargalant	2009	<i>Larix sibirica</i> Ldb.	50.3	101.0	1336	not fulfill the criteria	
4	Tsagaan-Uur (Khov 4)	Agitiin bel	2014	<i>Larix sibirica</i> Ldb.	50.3	101.3	1155	not fulfill the criteria	
5	Tarialan (Khov 5)	Suumhain durulj	2015	<i>Larix sibirica</i> Ldb.	49.3	102.2	1270	not fulfill the criteria	
6	Tarialan (Khov 6)	Khujirtiin durulj	2013	<i>Larix sibirica</i> Ldb.	49.3	102.1	1408	not fulfill the criteria	
7	Ikh Uul (Khov 7)	Ar bulgiin durulj	2014	<i>Larix sibirica</i> Ldb.	49.4	101.0	1702	not fulfill the criteria	
8	Tosontsengel (Khov 8)	Ulziit	2014	<i>Larix sibirica</i> Ldb.	49.4	101.0	1649	not fulfill the criteria	
9	Burentogtokh (Khov 9)	Tumurtii	2014	<i>Larix sibirica</i> Ldb.	49.3	99.5	1598	not fulfill the criteria	
10	Tumurbulag (Khov 10)	Tal bulag	2015	<i>Larix sibirica</i> Ldb.	49.2	99.5	2073	not fulfill the criteria	
11	Bayanzurkh (Khov 11)	Bayanzurkh	2017	<i>Larix sibirica</i> Ldb.	50.1	99.0	2150	not fulfill the criteria	
12	Renchinlkhumbe (Khov 12)	Jarain gol	2017	<i>Larix sibirica</i> Ldb.	51.2	99.5	1626	not fulfill the criteria	
13	Tsagaan-Uur (Khov 13)	Ongon	2017	<i>Larix sibirica</i> Ldb.	50.3	101.4	1186	not fulfill the criteria	
14	Erdenebulgan (Khov 14)	Zadiin davaa	2017	<i>Larix sibirica</i> Ldb.	50.2	102.0	1317	not fulfill the criteria	
Сэлэнгэ аймаг									
1	Shaamar (Sel 1)	Tsaram	2010	<i>Pinus sylvestris</i> L.	50.0	106.0	761	not fulfill the criteria	III
2	Altanbulag (Sel 2)	Togos uul	2013	<i>Pinus sylvestris</i> L.	50.0	106.3	795	Fulfill the criteria	III
3	Altanbulag (Sel 3)	Gun nuur	2010	<i>Pinus sylvestris</i> L.	50.1	106.3	630	not fulfill the criteria	III
4	Altanbulag (Sel 4)	Khond	2010	<i>Pinus sylvestris</i> L.	50.1	106.3	701	not fulfill the criteria	Non standard
5	Altanbulag (Sel 5)	Ehen davaa	2010	<i>Pinus sylvestris</i> L.	50.0	106.3	865	Fulfill the criteria	No seed crop
6	Khuder (Sel 6)	Tukhum	2013	<i>Pinus sylvestris</i> L.	49.4	107.1	907	Fulfill the criteria	Non standard
Хэнтий аймаг									
1	Dadal (Khen 1)	Uvgudiin uvur	2012	<i>Pinus sylvestris</i> L.	49.1	111.1	1066	not fulfill the criteria	No seed crop
2	Binder (Khen 2)	Yangiin ar	2013	<i>Pinus sylvestris</i> L.	48.3	110.2	1103	not fulfill the criteria	II
3	Binder (Khen 3)	Uvur khuurt	2013	<i>Pinus sylvestris</i> L.	48.3	110.2	1198	not fulfill the criteria	III
4	Batshireet (Khen 4)	Daliin ukhaa	2012	<i>Larix sibirica</i> Ldb.	48.4	110.0	1199	not fulfill the criteria	No seed crop
5	Umnudelger (Khen 5)	Ikh Ulziit	2013	<i>Larix sibirica</i> Ldb.	48.0	109.1	1395	not fulfill the criteria	No seed crop
6	Umnudelger (Khen 6)	Ikh Ulziit	2014	<i>Pinus sylvestris</i> L.	48.02	109.2	1424	not fulfill the criteria	No seed crop

МОНГОЛЫН ХАМГААЛ



Шинэсэн ойн үрийн ургацын үнэлгээ



Хөвсгөл, Хэнтий, Сэлэнгэ аймгуудад гүйцэтгэсэн судалгааны дүнгээс үзэхэд, 2017-2018 онуудад сибирь шинэс цэцэглэх үе буюу 5-р сарын сүүл 6-р сарын эхэн үед тус бүс нутгуудад хуурайшилттай үе тохиолдсон нь үрийн ургацад сөргөөр нөлөөлсөн байна. Модлог ургамлын цэцэглэлт, үр боловсрох явц, үрийн ургацад тухайн жилийн уур амьсгалын нөхцөл, ургамал ургалтын үеийн чийгийн хангамж, ургах орчны нөхцөл зэрэг олон хүчин зүйл нөлөөлж байна.





Судалгааны бүс нутгуудад эгэл нарсан ойн үрийн ургац 2-3 балл буюу дундаж ургацтай байна.





Таримал ойн хувьд ойн аж ахуйн арга хэмжээг хэрэгжүүлээгүйн улмаас модод үндсэндээ өсөлт багатай, титмийн биомассын алдагдал их, шилмүүс унаж титэм сийрэгжсэн, модод цэцэглэж, тоос хүртэн үрлэх насандаа хүрсэн боловч үрийн ургац байхгүй байна.







Хэнтий аймгийн Өндөрхаан станцын 2017 оны мэдээгээр ургамал ургамал ургалтын хугацааны нийлбэр тунадас 5-р сард 13.7 мм, 6-р сард 41.6 мм-ээр багасаж, дундаж температур 5-р сард 2.4⁰, 6-р сард 2.3⁰-аар тус тус нэмэгдсэн байна.




Хөвсгөл аймгийн Мөрөн станцын 2017 оны мэдээгээр ургамал ургалтын хугацааны нийлбэр тунадас 5-р сард 15 мм, 6-р сард 29.3 мм-ээр багасаж, дундаж температур 5-р сард 3.3⁰, 6-р сард 2.7⁰-аар тус тус нэмэгдсэн байна.




Сэлэнгэ аймгийн Сүхбаатар станцын 2017 оны мэдээгээр ургамал ургалтын хугацаанды нийлбэр тунадас 5-р сард 7.3 мм, 6-р сард 26.9 мм-ээр багасаж, дундаж температур 5-р сард 1.4⁰, 6-р сард 2.0⁰-аар тус тус нэмэгдсэн байна.

Судалгааны хүрээнд Сэлэнгэ аймагт ойн үрийн байнгын талбай байгуулсан



Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумын Шар хоолойн амны нарсан ойд Сэлэнгэ аймгийн Орхон бүсийн СДОА-тай хамтран ойн үрийн байнгын талбай байгуулах судалгааг 6 га талбайд гүйцэтгэсэн. Ой нь дан бүрэлдэхүүнтэй, насны II ангид хамаарах залуу насны ой бөгөөд дундаж диаметр 13 см, дундаж өндөр 8.4 м, модны тоо 324 ш/га, өтгөрөл 0,5 мод хоорондын зай дунджаар 2.5 ± 0.8 м, титмийн урт 1.8 ± 0.7 , амьд мөчир хүртэлх өндөр 1.3 ± 1.0 , бонитетийн IY анги.



СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ОЙН ҮРИЙН
БАЙНГЫН
ТАЛБАЙ



Хөвсгөл аймагт сонгон тусгаарласан ойн үрийн байнгын талбай



Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын Тал булагийн шинэсэн ой талбайн байршил нь өргөргийн $49^{\circ}26'22.0''$, уртрагийн $099^{\circ}58'40.4''$, далайн түвшнээс дээш 2073 м, газрын налуу баруун хойшоо 4° байна.



Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр сумын Онгоны нарсны эгэл нарсан ойд үрийн талбай байгуулах судалгааг Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр сумын СДОА-ийн дарга, мэргэжилтнүүдийн хамт үрийн талбай байгуулсан.



Хөвсгөл аймгийн Улаан уул сумын Улаан мод хэмээх газрын байгалийн шинэсэн ойд үрийн байнгын талбай байгуулах талбайг сонгосон. Судалгаанд Хөвсгөл аймгийн БОАЖГ-ын Ойн албаны дарга, мэргэжилтэн, Улаан уул сумын СДОА-ийн дарга, инженерүүдийн хамт үрийн талбай сонгох судалгааг гүйцэтгэлээ. Талбайн байршил нь өргөргийн $99^{\circ}04'58.4''$, уртрагийн $50^{\circ}45'30.0''$, д.т.д 1687 м өндөрт, зүүн өмнө зүгт харсан 2° налууд байрлана.



Хэнтий аймагт сонгон тусгаарласан ойн үрийн байнгын талбай



Хэнтий аймгийн Биндэр сумын Дэлгэр уулын шинэсэн ойд 14.2 га ой үрийн байнгын талбай байгуулах талбай. Үрийн байнгын талбайн байршил нь өргөргийн $110^{\circ}33'14.6''$, уртрагийн $48^{\circ}34'50.7''$, үнэмлэхүй өндөр дтд 1132 м, газрын налуу нь зүүн хойшоо 10° байна.



Хэнтий аймгийн Биндэр сумын Янгийн арын нарсан ойд 6.2 га талбайд үрийн байнгын талбай байгуулах талбайг сонгох судалгааг гүйцэтгэв. Талбайн байршил нь өргөргийн $110^{\circ}29'21.6''$, уртрагийн $48^{\circ}39'21.6''$, үнэмлэхүй өндөр дтд 1064 м, газрын налуу хойшоо 15° налуутай.

